

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ГЭРЭЭЛЭГЧИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ
НӨХӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН
ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Аудитын төлөвлөгөө

2016 он

АГУУЛГА

Аудитын нэр, код.....	2
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	2
Аудитын зорилт	2
Аудитын хамрах хүрээ.....	2
Эрсдлийн үнэлгээ	3
Аудитын арга зүй	3
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	3
Үндсэн мэдээлэл	3
Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	4
Аудитын хугацаа.....	4
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц.....	4
Аудитын эрсдэл /Хавсралт 1/	5

**БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

А.ЗАНГАД

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт

2. Аудитын код

YAГ-НАГ-/2016/07-НАГ

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт YAГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.21, Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн хийнэ.

4. Аудитын зорилт

Газрын тосны тухай хууль, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн 2014 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасныг шалган баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Гэрээлэгчийн 2014 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын өртөг нөхөгдөх зардлыг хянаж, баталгаажуулах;
- Газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо болон нөөц ашигласны төлбөр, Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны орлогын тооцоо, хуваарилалтыг хянаж, баталгаажуулах.

5. Аудитын хамрах хүрээ

Аудитад газрын тосны “Тосон-Уул XIX”, “Тамсаг-XXI”, “БХГ 97” талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК, Доншен газрын тос (Монгол) ХХК-иудын 2014 онд газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт, хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт, батлагдсан төсөв, төлөвлөгөө, холбогдох тайлан, мэдээ, судалгааг авч үзнэ.

6. Эрсдлийн үнэлгээ

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

7. Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 4100, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

8. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Газрын тосны тухай хууль
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- БНМАУ-ын газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам
- Бүтээгдэхүүн хуваах гэрээ
- УИХ, ЗГ-ын тогтоол, Уул уурхайн сайд, ГТГ-ын даргын баталсан дүрэм, журам, Гэрээлэгчтэй байгуулсан нэмэлт протокол
- Холбогдох бусад хууль, тогтоомж.

9. Үндсэн мэдээлэл

Газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг 1991 оны “Газрын тосны тухай” хууль, “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-аар зохицуулж ирсэн бөгөөд 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр УИХ-аас тус хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдөж эхэлсэн байна.

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 31 талбай ялгаснаас өнөөгийн байдлаар 21 талбайд 16 гэрээлэгч аж ахуйн нэгж (компани) Бүтээгдэхүүн хуваах гэрээг ГТГ-тай байгуулан, Засгийн газраар батлуулан ажиллаж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан компаниудын 21 хувь нь Монгол Улсын, 36 хувь нь БНХАУ-ын, үлдсэн 43 хувь нь бусад орны хөрөнгө оруулалттай байна.

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар хоногт дунджаар 26,944 баррель буюу 3,656 тонн тос олборлож, 1998-2015 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэлх хугацаанд нийт 35.5 сая баррель буюу 4.8 сая тонн газрын тос олборлож, 33.6 сая баррель буюу 4.5 сая тонныг БНХАУ-д экспортолж, нийт 974.1 тэрбум төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Газрын тосны салбарт олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК 2014 онд “Тамсаг ХХI” гэрээт талбайгаас 322,338 тонн газрын тос олборлож, 291,205 тонныг экспортолсон, “Тосон-Уул XIX” гэрээт талбайгаас 618,034 тонн газрын тос олборлож, 568,255 тонныг экспортолсон, 2015 онд “Тамсаг-ХХI” гэрээт талбайгаас 465,068 тонн газрын тос олборлож, 445,681 тонныг экспортолсон, “Тосон-Уул XIX” гэрээт талбайгаас 654,759 тонн газрын тос олборлож, 589,760 тонныг экспортолсон, Доншен газрын тос (Монгол) ХХК “БХГ 97” гэрээт талбайгаас 2014 онд 61,618 тонн газрын тос олборлож, 61,516 тонныг экспортолсон, 2015 онд 63,101 тонн газрын тос олборлож, 64,328 тонныг экспортолсон байна.

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул хянан удирдаж, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн НАГ-ын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Д.Дорждулам, шинжээч М.Туул, А.Ариунзаяа болон АМГТГ-ын холбогдох мэргэжилтнүүд хамтран гүйцэтгэнэ.

11. Аудитын хугацаа

Аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 12-нд эхэлж, 2016 оны 12 дугаар сарын 30 - нд дуусган Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2017 оны 1 дүгээр сарын 25-ны дотор Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.

12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

а. Боловсон хүчин: УАГ - 95* 5 хүн – 475 хүн/өдөр

б. Санхүүгийн нөөц:

Цалингийн зардал - 41,068.5 мянган төгрөг

Бичиг хэргийн зардал – 220.0 мянган төгрөг

в. Аудитын нийт зардал: 41,068.5 мянган төгрөг

г. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, диктафон, скайнер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг

Танилцсан:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА

Б.БАТТУЯА

Хянасан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.АЛТАНЗУЛ

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
ШИНЖЭЭЧ

Л.ХӨНГОРЗУЛ
Д.ДОРЖДУЛАМ
А.АРИУНЗАЯА
М.ТУУЛ